



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 08 дугаар сарын 11

Дугаар 3

Улаанбаатар хот

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН III ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын III хуралдаан 2025 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 10.00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д ^{87.8}хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны,
Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн*

2. Эрчим хүчний салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явц

*Эрчим хүчний сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн*

3. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдинням*

4. Ган, зуншлагын нөхцөл байдал, ирэх улирлын цаг агаарын төлөв байдлын талаар

*Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулга*

5. Бусад

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}-д заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах улсын албад, бүх шатны онцгой комисс, төрийн байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1.1. Өвөлжилт хүндрэх, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл тохиолдох, зам, даваа хаагдах гэх мэт нөхцөл байдал үүссэн үед хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах, иргэдэд хүнс тэжээл, эрүүл мэндийн болон төрийн бусад үйлчилгээг шуурхай тасралтгүй хүргэх төлөвлөлтийг нарийвчлан гаргаж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор бүх шатанд авч хэрэгжүүлэх;

1.2. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх, хариуцсан салбар, орон нутгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.3. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, гүйцэтгэл, үр дүнгийн талаар 14 хоног тутамд Улсын онцгой комисст мэдээ, тайланг ирүүлэх;

Хоёр. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

2.1. Холбогдох мэргэжлийн байгууллагуудаас гаргаж буй бэлчээрийн даац, ган, зудын эрсдэлийн үнэлгээ, хүйтний улирлын цаг агаарын төлөв байдал болон бусад болзошгүй эрсдэлийн зарлан мэдээллийг иргэд олон нийтэд тогтмол шуурхай хүргэх;

2.2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүх шатанд хангах, аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээл бэлтгэх ажлыг шуурхай зохион байгуулах, зуншлага тааруу хадлан бэлтгэх боломжгүй аймаг, сумдыг бусад аймаг, орон нутгаас өвс тэжээл бэлтгэх, худалдан авах боломжоор хангах зохицуулалтыг 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хийж гүйцэтгэх;

2.3. 2025-2026 оны өвөл, хавар отор, нүүдэл хийх малчдын судалгаа, оторлох малын тоо, толгойг аймаг, орон нутгаар нэгтгэн гаргах, холбогдох зохион байгуулалтыг нарийвчлан хийж гүйцэтгүүлэх, урьдчилсан тооцоо судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах;

Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр, Гаалийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Р.Отгонжаргал, Нийслэлийн Засаг бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

3.1. Мал, махны экспортыг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг хангах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.2. Мах бэлтгэл, малын тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй хамтран зудын эрсдэлийг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, өвс, тэжээлийн дотоодын хэрэгцээг хангах, нэмэгдүүлэх чиглэлээр тусгайлсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

3.3. Өвс, малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, экспортыг түр хугацаанд зогсоох, импортыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран авч хэрэгжүүлэх;

Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр болон Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга нарт:

4.1. Байгалийн хадлан бэлтгэх боломжтой сум, баг, талбайн тоо, хэмжээг нарийвчлан гаргаж гантай, зуншлага тааруу аймгуудтай мэдээлэл солилцож хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хадлан бэлтгэх боломжоор хангах ажлыг 8 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулах;

Тав. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга нарт:

5.1. Хадлангийн бүс нутгийг хамгаалах, сэргээх, зүй зохистой ашиглах асуудлаар нэгдсэн бодлого, төлөвлөгөө боловсруулж Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх;

Зургаа. Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн засаг дарга нарт:

6.1. Эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах түлш, нүүрсний нөөцийг шаардлагатай хэмжээнд бүрдүүлэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийг тооцоолж авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөлт хийж, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

Долоо. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдинням, Зам, тээврийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

7.1. Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой хэмжээнд хангах, хомсдол үүсгэхгүй байхад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

7.2. Эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийн нүүрсний нийлүүлэлтийг хангаж байгаа “Багануур”, “Шарын гол”, “Шивээ Овоо” болон орон нутгийн нүүрсний уурхайн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, түлш, шатахууны нөөцийг бүрдүүлэх, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг тогтоосон хугацаанд хангуулах;

Найм. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Н.Учрал, Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Г.Дамдинням нарт:

8.1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, тасалдал хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх хүрээнд шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдэд шатахууны нөөц бүрдүүлэхэд шаардлагатай эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгох боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

8.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д тусгагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахыг барьж байгуулах” зорилтыг хэрэгжүүлэх ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулах, агуулах барих төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох, уг зээлийн татаасыг улсын төсөвт суулгах арга хэмжээ авч ажиллах;

8.3. “Рашаант” дахь улсын нөөцийн агуулахын концессийн гэрээг дүгнэж дуусгавар болгох, төслийг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт үе шаттай тусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;

Ес. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Бат-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

9.1. Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх, хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;

Арав. Зам тээврийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Дэлгэрсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

10.1. Салбарын хэмжээнд өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж авто зам хариуцагч байгууллагуудад шаардлагатай техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, нөөц бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Арван нэг. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, бүх шатны Засаг дарга нарт:

11.1. Байгаль цаг уурын гаралтай аюулт гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагаанд шаардлагатай бие бүрэлдэхүүн, тэдгээрийн хувцас, хэрэглэл, багаж, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, тоо хэмжээ, хүчин чадлыг тогтмол нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

Арван хоёр. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Энхбаяр, Цаг уур орчны шинжилгээний газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулга, ЗГХЭГ-ын Хэвлэл

мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Баасандамба, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал, Улсын онцгой комиссын гишүүн Г.Гэрэл, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

12.1. 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч, зуд болох эрсдэлтэй байгааг илэрхийлж буй гангийн эрсдэлийн үнэлгээ, бэлчээрийн ургамлын ургалтын байдал, малын тарга хүч зэрэг бодит нөхцөл байдлын талаар олон нийтэд тогтмол мэдээлэл өгч, иргэд, аж ахуйн нэгжийг өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангах уриалга гаргаж хэрэгжүүлэх;

Арван гурав. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхланд:

13.1. 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх эрсдэлтэй байгаа тул ирэх 2026 оны улсын төсөвт Засгийн газрын нөөц сан, аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэн тусгаж батлуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулахад анхаарч ажиллах;

Арван дөрөв. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар болон аймгийн Засаг дарга нарт:

14.1. Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5-д тус тус заасны дагуу хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тасалдуулахгүй байхад онцгой анхаарах, мах, төмс, хүнсний ногооны дотоодын нөөцийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, тухай бүр танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгав.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ